



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№183 /393/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.10.12

Цаг үе, үйл явдал

## ЭМЧ НАР ЧУУЛЛАА



Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын Эрүүл мэндийн төвийн дарга, их эмч нарын цугларалт энэ сарын 10-11-ний өдрүүдэд Батлан хамгаалах яамнаа болж өндөрлөлөө.

Цугларалтад оролцогчид өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, туршлага, сургамжаа тодотгохын зэрэгцээ цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн асуудал, Зэвсэгт хүчний эрүүл мэндийн тогтолцооны өнөөгийн байдал, цаашдын

чиг хандлага, эмч, эмнэлгийн мэргэжилтний нөхөн хангалт, сургалт, нийгмийн хамгаалал, эрх зүйн орчныг сайжруулах зэрэг ерөнхий асуудлын хүрээнд санал солилцсон юм.

Мөн энэ жилийн хувьд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын эмч, сувилагчдын 60 орчим хувь нь цэргийн алба хаагч учир цэргийн мэргэжлийн чиг баримжаа олгох талаар голчлон анхаарч цугларалтаа зохион байгуулж байгааг холбогдох албаны хүмүүс онцлов.

**Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн Эрүүл мэндийн төв, эмнэлгийн албаны дотрын их эмч дэслэгч О.Одончимэг:**

-ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтсээс жил бүр зохион байгуулдаг тус цугларалтад анх удаа оролцлоо. Миний бие 2021 оноос Зэвсэгт хүчний 336 дугаар ангид томилогдон ажиллаж байна. Эмчийн мэргэжил аль ч шатандаа хүний амь настай холбоотой үйл ажиллагаа явуулдаг учир асар их үүрэг хариуцлага, үргэлж өссөн дэвшихийг шаарддаг. Үүний

зэрэгцээх орноо батлан хамгаалах үйлсэд хүчин зүтгэж хос тангараг өргөнө гэдэг маш хүнд ачаа. Ийм ч учраас тус цугларалтад хамрагдаж хоёр хоногийн хугацаанд цэргийн албаны эрх зүй, хууль тогтоомж, тэдгээрийн хүрээнд хэрхэн ажиллах, цаашид ямар чиглэлд өөрийгөө хөгжүүлэх, нэгтгэл, анги, байгууллагын алба хаагчдад тулгамддаг эрүүл мэндийн нийтлэг асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар үнэ цэнтэй мэдээллүүдийг олж авсандаа баяртай байна.

## МЭДЛЭГ ТУРШЛАГАА СОЛИЛЦСОН НЭГЭН ӨДӨР...



Цэргийн төв эмнэлгийн Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн төвийн хамт олон "Ажлын нэг өдөр" өдөрлөгийг зохион байгуулжээ. Өдөрлөгт эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, хагалгааны эмч, сувилагчаар ажиллаж байсан ахмадууд оролцож, сүүлийн хоёр жилд ЦТЭ-т хийгдсэн бүтээн байгуулалт, шинэчлэлтэй танилцахын зэрэгцээ эрчимт эмчилгээний болон мэдээгүйжүүлэг хагалгааны тасгуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хамтран оролцож мэдлэг, туршлагаа хуваалцсан аж. Ахмад сувилагч С.Даваасүрэн: "Залуу боловсон хүчин, мэргэжилтэн, хүүхдүүдийг дагалдан хагалгаанд орж нойрсуулах сувилагчийн

үүргийг туслан гүйцэтгэлээ. Орчин үеийн шаардлага хангасан дэвшилтэд тоног төхөөрөмжөөр хангагдсан, хийж байгаа үйлдэл бүхэн цахимжсан, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг нь ахмадууд бидэнд маш сайхан сэтгэгдлийг төрүүллээ. Бидний залгамж халаа болсон залуу боловсон хүчнүүд мэргэжилдээ чадварлаг байгааг харахад сэтгэл хангалуун байна. Биднийг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн Цэргийн төв эмнэлгийн Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн төвийн хамт олон та бүхэндээ баярлалаа. Эрүүл энхийн манаанд нь амжилт хүсэж, урт удаан наслахын ерөөл дэвшүүлье" гэжээ.

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

## ХҮЙТНИЙ УЛИРЛЫН ДҮРЭМТ ХУВЦСАНД ИРЭХ САРЫН 14-НИЙ ӨДӨР ШИЛЖИНЭ

ЗХЖШ-ын даргын болжээ. тушаалаар Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч нарыг 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс, УБХИС-ийн сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нарыг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хүйтний улирлын дүрэмт хувцсанд шилжүүлэхээр

Хүйтний улирлын дүрэмт хувцсанд шилжиж буйтай холбогдуулан Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад хувцасны үзлэг явуулж, дүнг илтгэхийг ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нар болон Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлалууд үүрэг болгосон байна.



## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 627,677,595

Эдгэрсэн  
Нийт: 607,183,872

Нас барсан  
Нийт: 6,563,773

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ: “ЧИНГИС ХААН” ХААД, ЯЗГУУРТНЫ МУЗЕЙ МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ОЮУН САНАА, ЗҮРХ СЭТГЭЛ, ИТГЭЛ ҮНЭМШЛИЙН ХУВЬД НЭГДЭГЛЭН ЗАНГААЛАХ



жилийн тэгш ой тохиож байна.

Их эзэн Чингис хаан Монголын төдийгүй дэлхий ертөнцийн түүхэнд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж, хүн төрөлхтний хөгжил дэвшлийн үндэс суурийг цогцлоход онцгой гавьяа байгуулсан аугаа их хаан билээ.

Эзэн хаан, түүний залгамжлагчид Евроазийн өргөн уудам нутагт Ази, Европын олон үндэстэн хоорондын дайн тулаан, зөрчил, тэмцэлдээнийг зогсоож, дэлхий ертөнцөд “Монголын их амар амгалан”-г тогтоож, улс түмнүүдийн харилцаа холбоо, эе эвийг бэхжүүлэн, оюун санаа, шашин шүтлэг, худалдаа арилжаа, соёл, урлаг, шинжлэх ухаан хийгээд тухайн үеийн хүний нийгэм хөгжин дэвжих таатай нөхцөлийг бүрдүүлж чадсан юм.

Дэлхийн улс түмэн үнэт зүйлсээ харилцан хүлээн зөвшөөрч, олон соёл иргэншил, шашин шүтлэг зэрэгцэн орших учиртайг анхлан мэдрүүлж, хүн төрөлхтний хөгжилд онцгой гавьяа байгуулсан Их Эзэн Чингис хааны түүхэн үйл хэргийг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрсөн.

2005 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг дэлхий нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлэх тогтоол гаргаж байсан билээ.

Чингис хаан бол дэлхийн олон үндэстэн, ард түмний энх тайвны төлөө тэмцэж, тив, дэлхийд амар амгаланг цогцлоон, хүн төрөлхтний өмнө аугаа үйл хэргийг бүтээсэн их хүмүүн хэмээн олон улсын түүхчид, эрдэмтэн судлаачид онцлон тэмдэглэдэг юм.

Их эзэн Чингис хаан болон түүнийг залгамжилсан их хаадынхаа үйл хэргийг монголчууд бид судлан шинжилж, хадгалан хамгаалж, улс орондоо төдийгүй дэлхий ертөнцөд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх нь Эзэн хаанаараа овоглосон хүн бүрийн үеийн үед эрхэмлэн дээдэлж явах учиртай ариун үүрэг мөн. Ийм учраас Төрийн тэргүүн зарлиг буулгаж, монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахих буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн

Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн дээдэлж, Монгол төр, айл өрх, албан байгууллага бүр хүндэтгэн залж, Их хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсан билээ.

Өнөөдөр та бидний өмнө сүндэрлэн байгаа “Чингис хаан” хаад, язгууртны музей манай ард түмэн, бидний үр хүүхэд, ирээдүй хойч үе маань эх орон, ард түмэн, өвөг дээдэс, үүх түүх, үнэт зүйлээрээ бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, дэлхий дахинаа эх орноо сурталчлан таниулах, аугаа түүхт монгол үндэстнийг оюун санаа, зүрх сэтгэл, итгэл үнэмшлийн хувьд нэгтгэн зангидаж, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

Цаашид Монгол төр, бидний ирээдүй болсон үр хүүхэд, хойч үеийнхэн маань Их хаадынхаа үйл хэргийг улам бүр үргэлжлүүлэн судалж, сурталчлан таниулж, Монгол түмний их бүтээн байгуулалт, бахдал омогшлын бэлгэдэл болсон музейг өргөтгөн, үзмэр, үйлчилгээ, сан хөмрөгийг нь арвижуулан баяжуулж, дэлхий нийтийн анхаарлыг татсан түүхийн музей, олон улсын судалгааны төв болгон хөгжүүлэх учиртай.

2019 оны Монгол Улсын Засгийн газрын 280 дугаар тогтоолоор “Чингис хаан” музей байгуулах шийдвэр гарсан цаг мөчөөс өнөөг хүртэл дэлхий нийтийг хармарсан цар тахлаас авахуулаад хүндрэл, бэрхшээл олонтоо тохиолдсон ч музейг

богино хугацаанд барьж ашиглалтад орууллаа.

Монголчууд бид оюун ухаан, мэдлэг чадвар, хүч хөдөлмөрөө нэгтгэн эрч хүчтэй хамтран ажиллаж чадвал ямар ч зүйлийг хийж бүтээж чаддаг гэдгээ энэ түүхэн бүтээн байгуулалтаар бас дахин нотлон харууллаа.

Монголын түүхэнд тодоор бичигдэн үлдэх энэ түүхэн музейг бүтээн байгуулах их үйлсэд оройлон зүтгэж, сэтгэл зүтгэлээ зориулан манлайлан оролцсон эрдэмтэн судлаачид, уран бүтээлчид, барилгачид, инженер, техникийн ажилчид, баялаг бүтээгчид, төрийн албан хаагчид, Соёлын яам, тус музейн удирдлага, хамт олон болон бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцсон бүх хүн, байгууллага, хамт олонд ард түмнийхээ нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж, чин сэтгэлийн халуун баяр хүргэе.

“Чингис хаан” хаад язгууртны музей Чингис хаан судлалын олон улсын гол төв болж, их хаадын суу алдрыг дэлхий дахинаа үеийн үед түгээн дэлгэрүүлж байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлэе.

Дэлхийн мянганы суут хүмүүн Эзэн Богд Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойг тохиолдуулан Монголын ард түмний олон зуун жилийн хүсэл мөрөөдлийн биелэл болсон Эзэн Богд Чингис хааны хүндэтгэлийн өргөө- “Чингис хаан” хаад язгууртны музейн өндөр үүдийг өргөж, алтан босгыг мялаан албан ёсоор ёслол төгөлдөр нээж байна.

Мөнх тэнгэрийн хүчин дор Их Эзэн Чингис хааны суу алдар, сүр хүч монголчууд биднийг өнө мөнхөд ивээх болтугай.

“Чингис хаан” хаад, язгууртны музейг нээх ёслол 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр боллоо.

Музейд:

Монголын эртний төрт улс (Хүннү, Сяньби, Жужан);  
Эртний нүүдэлчдийн төрт улс (Түрэг, Уйгур, Хятан);  
Их Монгол Улс;  
Монголын Их эзэнт улс;  
Чингис хааны угсааны хаад, язгууртны (XIV-XX зууны эхэн үе);  
Дэлхий дахин ба Монголчуудын танхим (Монгол бахархлын танхим);  
Их хааны хүндэтгэлийн өргөө гэсэн байнгын үзмэрийг байршуулсан байна.

Музей 12 мянга орчим үзмэртэй бөгөөд 92 хувь нь эх үзмэр бөгөөд үлдэх хувь нь гадаадын 10 гаруй улсын музей, номын сан, архивт байгаа зарим эд өлгийн зүйлсийн хуулбар, уран бүтээл юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх музейн нээлтэд хэлсэн үгийг бүрэн

эхээр нь хүргэж байна. “Их Монгол Улсын гал голомтыг сахин суугаа манай улсын ард иргэд ээ,

Дэлхий даяар тархан суугаа элэг нэгт монгол ахан дүүс ээ,

Эрхэм хүндэт зочид, эрхэм нөхөд өө,

Ерөөл бэлгэ, өлзий учрал тэгш дүүрэн бүрдсэн энэ сайхан өдөр Эзэн Богд Чингис хаан болон түүний залгамжлагчдын түүхэн гавьяа, үйл хэргийг алдаршуулж, суу алдрыг мөнхжүүлэх зорилгоор, даяар Монголын ариун гал голомт, улсын нийслэл Улаанбаатар хотноо “Чингис хаан” хаад, язгууртны музейг нээж, далай их өвөг дээдэстээ гүн хүндэтгэл үзүүлэхээр Та бид хуран цуглаад байна.

Энэ жил монголчууд бидний хувьд төрт ёс, түүх соёл, хууль цаазын дор монгол туургатныг нэгтгэн, өнө эртнээс улбаатай Монгол төрийн гал голомтыг бадраан, Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсаа байгуулж, монгол үндэстний суу алдрыг дэлхий дахинд тунхаглан мандуулсан Эзэн Богд Чингис хааны мэндэлсний 860

АЛДАР СПОРТ ХОРООНЫ ТАМИРЧИН Э.ЭНХТАМИР МӨНГӨН МЕДАЛЬ ХҮРТЭВ



Бахрайн улсын нийслэл Манама хотод зохион байгуулагдаж буй Хүндийн өргөлтийн Ази тивийн аварга шалгаруулах Эрэгтэйчүүдийн 50,

эмэгтэйчүүдийн 31 дэх удаагийн тэмцээнд ОУХМ дэслэгч Ч.Март дасгалжуулагчтай Үндэсний шигшээ баг Алдар спорт хорооны тамирчин ОУХМ Э.Энхтамир 59

кг-ийн жинд Огцом өргөлтөөр 86, 89, 92 кг-ыг өргөж Азийн аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медаль хүртлээ.

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №03

3. ШИЛБЭ

Шилбэ бол И эгшиг, мөн Яа, Ва, үгийн дунд орох Да, Та, галигийн Ха, Лх үсгийн бүрдүүлэгч юм.

Зурлагын хувьд, өмнөх хичээлд үзсэн шүд махбодоос 2 дахин урт бичдэг. Бусдаар шүдтэй яг адилхан. Нуруун дээрээс эхлэн шүднээс 2 дахин урт зураас татаж, буцааж гаргасан зураасаараа нуруундаа зайгүй нийлүүлээд доош нурууг үргэлжлүүлэн татах дарааллаар, үзгээ салгалгүй бичээрэй. Хэт урт бичиж болохгүй.

Дармалаар:

Бичмэлээр:

